



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ” ТӨХК-Д

Худалдаа, хөгжлийн банк, 14210 Энхтайваны өргөн чөлөө
19, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Улаанбаатар, Монгол Улс
Утас: (976-11) 31-19-14, Факс: (976-11) 31-19-44
Эшуудан: info@tdbcapital.mn Вэб хуудас: www.tdbcapital.mn

Огноо 2019. 05. 13 № 60/2019

**Хуваарилалтын төлөвлөгөө
хүргүүлэх тухай**

Тус компани нь “Инвескор ББСБ” ХК-ийн үнэт цаасны нийтэд санал болгох ажлын үндсэн андеррайтераар ажиллаж байгаа бөгөөд “Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалтын төлөвлөгөө”-г хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 1 хуудас.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БАТЧИМЭГ

ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ХУВААРИЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Инвекскор ББСБ” ХК-ийн нэмж гаргаж буй 10,759,188 ширхэг хувьцааны 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчид, 15 хувийг олон нийтэд санал болгон арилжаалахаар төлөвлөсөн бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар 17.6-18.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьж байна.

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 2 дугаар бүлэгт заасан “ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГА”-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Хөрөнгө оруулагчид	Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь	Санал болгох хувьцааны тоо	Санал болгох үнэ /төгрөг/ үнэ	Татан төвлөрүүлэх хөрөнгө /тэрбум төгрөг/ хэмжээ	
	Доод үнэ	Дээд үнэ	Доод хэмжээ	Дээд хэмжээ	
Стратегийн хөрөнгө оруулагч	85%	9,145,310	1,650	1,750	15.1
Олон нийт	15%	1,613,878	1,550	1,650	2.5
Нийт		10,759,188		17.6	18.7

Хувьцааны хуваарилалт хийх үйл ажиллагааг андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцэж, Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ыг баримтлан явуулна. Хувьцааны хуваарилалт нь Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга хүлээн авах захиалгын сан болон Олон нийтээс захиалга хүлээн авах захиалгын сан тус бүрээр дараах байдлаар хийгдэнэ.

Стратегийн хөрөнгө оруулагчдаас авсан захиалгын хуваарилалт

- Стратегийн хөрөнгө оруулагчаас хүлээн авсан хувьцааны нийт захиалгын тоо нь стратегийн хөрөнгө оруулагчид санал болгон гаргасан хувьцааны тооноос илүү байх тохиолдолд үнийн ахлах дарааллыг баримтлан, хувьцааг арилжих нэг үнийн түвшинг тогтооно.
- Стратегийн хөрөнгө оруулагчийн хувьцааны хуваарилалтыг андеррайтер болон Үнэт цаас гаргагч хамтран хийнэ.

Олон нийтээс авсан захиалгын хуваарилалт

- Олон нийтээс хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан хувьцааны тооноос илүү байх тохиолдолд үнийн ахлах дарааллыг баримтлан, үнэт цаасыг арилжих нэг үнийн түвшинг тогтооно.
- Үнийг тогтоосны дараа тогтоосон үнэ болон түүнээс дээгүүр үнээр өгсөн захиалгуудыг цаг хугацааны дарааллаас үл хамаарч захиалсан хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хуваарилна.
- Үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийн дүнг заасан захиалгыг тухайн үнэт цаасыг арилжих үнийн түвшинд биелүүлж, хуваарилалтыг хийнэ.